

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ГУЧИННАЙМДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны арванхоёрдугаар сарын 31-ний 10 цаг 05 минутад эхэлж, 12 цаг 05 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 59 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Дархан уул аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35 ¹ дугаар зүйлийн 35 ¹ .1.8, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн: Цэрэнгийн Сүхбаатарыг Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Дархан-Уул аймгийн Засаг дарга А.Энхболдод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Орхон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн: Дугарсүрэнгийн Эрдэнэчимэгийг

		<p>Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Мягмарсүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны зарим ажилтныг удирдах албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар - Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилуулахаар 	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын дүгнэлтийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаас:</p> <p>Энх-Амгалангийн Энхзаяаг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нарангэрэлд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын дүгнэлтийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаас:</p> <p>Харнүдэнгийн Мөнхзулыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын</p>

		<p>даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нарангэрэлд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга, өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Эрх зүй, дотоод хяналтын газарт мэргэжилтнээр ажиллаж байсан Ж.Очирхуягаас гаргасан гомдлыг хянан шийдвэрлэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>“Сахилгын шийтгэл ногдуулах тухай” Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга, өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын 2015 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Б/166 дугаар тушаалыг эс зөвшөөрч, тус агентлагийн Эрх зүй, дотоод хяналтын газрын мэргэжилтнээр ажиллаж байсан Ж.Очирхуягаас Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдлийг хянан шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “Нэг” дэх хэсгийн 3.4-ын “д”-д заасныг удирдлага болгон:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” Шударга, өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын 2015 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Б/166 дугаар тушаалыг хууль зүйн үндэслэлгүй гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх 2. “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” Шударга, өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын 2015 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Б/166 дугаар тушаалыг хүчингүй болгож шийдвэрлэхийг тус агентлагийн даргад даалгах. 3. Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаас гарсан тогтоолыг Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д заасны дагуу биелүүлж ажиллахыг Шударга, өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

5	<p>"Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авсан арга хэмжээ, ахиц дэвшил, үр дүн" сэдвээр Төрийн албаны зөвлөлийн Барилга хот, байгуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн сонсгол сонсож хэлэлцэх</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.3, 39 дүгээр зүйлийн 39.6, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 4.4 дэх заалтыг тус тус баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5-д "төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх", 27 дугаар зүйлийн 27.2.2-т " улс төрийн албан тушаалтан уг албан тушаалаас өөрчлөгдөх нь төрийн жинхэнэ албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй байх", Төрийн албаны зөвлөлийн 2013 оын 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.6-д "Салбар зөвлөл нь ... өөрийн үйл ажиллагааг аливаа байгууллага, албан тушаалтнаас хараат бус, бие даасан байдлаар явуулна" гэж тус тус заасныг хангалтгүй хэрэгжүүлсэн гэж дүгнэх</p> <p>2. Хууль, тогтоомжийг хэрэгжилтийг хангаж, Салбар зөвлөлийн бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан хаагчдыг улс төрийн нөлөөллөөс ангид, тогтвор сууршилтай ажиллуулахыг салбар зөвлөлийн дарга С.Магнайсүрэнд үүрэг болгох</p> <p>3. Зөрчлүүдийг арилгах асуудлаар тодорхой ажил зохион байгуулж, хэрэгжилтийг 2016 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд ирүүлэхийг салбар зөвлөл /С.Магнайсүрэн/-д даалгах</p> <p>4. Энэхүү тогтоолыг салбар зөвлөлд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба /С.Цэдэндамба/-нд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
	"Төрийн албаны тухай хууль тогтоомжийн	Төрийн албаны зөвлөлийн Сангийн

6	хэрэгжилтийг хангах талаар авсан арга хэмжээ, ахиц дэвшил, үр дүн" сэдвээр	яамны дэргэдэх Салбар зөвлөлийн сонсгол сонсож хэлэлцэх асуудлыг хойшлуулахаар шийдвэрлэв.
---	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА